

## Телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалт

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 275 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх зохицуулалтын чиглэлийг тодорхойлно.

### 2. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагад хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1 “Өндөр нягтрал” (HD) гэж 720 пикселээс их нягтралтай дүрсийн форматыг;
- 2.2 “Стандарт нягтрал” (SD) гэж 720 пикселээс бага нягтралтай дүрсийн форматыг;
- 2.3 “MPEG2/H262” гэж тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн сигналыг (тоон дуу ба дүрс) шахах ISO/IEC13818 стандарт. Анхын хувилбар нь 1996 онд батлагдсан.
- 2.4 “MPEG4/H.264” гэж тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн сигналыг (тоон дуу ба дүрс) шахах ISO/IEC14496 стандарт. Анхын хувилбар нь 1999 онд батлагдсан.
- 2.5 “Телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн аналог систем” гэж телевизийн студийн гаралтаас гарсан аналог дохиог газрын аналог сүлжээгээр дамжуулж, хэрэглэгчийн аналог хүлээн авах төхөөрөмжөөр хүлээн авах бүх сүлжээ, тоног төхөөрөмжийн иж бүрдлийг;
- 2.6 “Телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн тоон систем” гэж телевизийн студийн гаралтаас гарсан тоон дохиог газрын тоон сүлжээгээр дамжуулж, хэрэглэгчийн тоон хүлээн авах төхөөрөмжөөр хүлээн авах бүх сүлжээ, тоног төхөөрөмжийн иж бүрдлийг;
- 2.7 “Телевизийн газрын сүлжээ” гэж телевизийн студийн гаралтад гарч буй дохиог ~~радио~~ цахилгаан соронзон долгионоор телевизийн хүлээн авагчруу дамжуулах модулятор, нягтруулагч, нэвтрүүлэгч, зурвасын шүүр болон антен фидерийн байгууламжийн иж бүрдлийг;

## ТӨСӨЛ

2.8 “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” гэж радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээ, радио телевизийн үйлчилгээ, олон суваг дамжуулах үйлчилгээний төрлүүдийг;

- “Радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээ” гэж радио телевизийн газрын сүлжээ байгуулж, гэрээний үндсэн дээр тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийг тодорхой хамрах хүрээнд дамжуулж, хэрэглэгчдэд үнэ төлбөргүй үзэх боломжоор хангах үйлчилгээг;
- “Радио телевизийн үйлчилгээ” гэж үг, дуутай эсхүл үг, дуу, хөдөлгөөнт дүрс, графиктай агуулгыг хөтөлбөрийн дагуу бэлтгэж, гэрээний үндсэн дээр радио телевизийн газрын, олон суваг дамжуулах, интернэтийн зэрэг харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэх үйлчилгээг;
- “Олон суваг дамжуулах үйлчилгээ” гэж утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр радио, телевизийн олон сувгийг хэрэглэгчдэд гэрээний үндсэн дээр төлбөртэй дамжуулан хүргэх үйлчилгээг;

2.9 “Шилжилт” гэж телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон системд шилжүүлэх үйл явцыг;

2.10 “Шилжилтийн хугацаа” гэж телевизийн газрын тоон сүлжээний эхний нэвтрүүлэгчийг асааж эхлэхээс телевизийн газрын аналог сүлжээний сүүлчийн нэвтрүүлэгчийг унтраах хүртэлх хугацааг;

2.11 “Тоон телевизийн төрийн сүлжээ” гэж орон даяар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан телевизийн газрын тоон сүлжээг;

2.12 Төрөөс зайлшгүй дамжуулах телевизийн өргөн нэвтрүүлгийн телевиз гэж иргэдээс үйлчилгээний аливаа төлбөр, хураамж авахгүйгээр, кодлохгүйгээр газрын тоон телевизийн төрийн сүлжээ, өргөн нэвтрүүлгийн хиймэл дагуулаар тодорхой тооны телевизийн нэвтрүүлгийг дамжуулан хүргэхийг хэлнэ.

## 3. РАДИО ДАВТАМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ, АШИГЛАХ СТАНДАРТ, ДАМЖУУЛАХ ЗАРЧИМ

3.1 Телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон системд шилжүүлэхдээ давтамж ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, олон нийтэд хүргэх өргөн нэвтрүүлгийн дуу, дүрсийн дамжууллын чанарыг сайжруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, контентийн чанарыг сайжруулах чиглэлийг баримтлана.

3.2 Харилцаа холбооны зохицуулах хорооны (цаашид “Зохицуулах хороо” гэх) 2013 оны 12 дугаар тогтоолд тусгагдсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын зохицуулалт, ашиглах стандарт нь хүснэгт 1, дамжуулах урсгалын хурд нь хүснэгт 2-д зааснаар тодорхойлогдно.

Хүснэгт 1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвас, стандарт

Ашиглах радио давтамжийн зурвас	Нэг нэвтрүүлэгчийн ашиглах зурвасын өргөн	Ашиглах стандарт	Кодлол	Хэрэглэгчийн төлбөр
<b>а) Телевизийн газрын сүлжээний үйлчилгээ</b>				
470-582 МГц	8 МГц	DVB-T2	Хийхгүй	төлбөргүй
<b>б) Олон суваг дамжуулах үйлчилгээ</b>				
582-686 МГц	8 МГц	DVB-C / C2 DVB-T / T2	Олон нийтийн телевизээс бусад телевизийн сувгууд кодтой байж болно	төлбөртэй

Хүснэгт 2. Нэг телевизийн сувгийн эзлэх урсгалын хурд

DVB-T / MPEG-2/H262		DVB-T2 / MPEG4/H264	
Стандарт нягтрал	Өндөр нягтрал	Стандарт нягтрал	Өндөр нягтрал
3 Мбит/с	16 Мбит/с	1.5 Мбит/с	8 Мбит/с

#### 4. ТЕЛЕВИЗИЙН АНАЛОГИ НЭВТРҮҮЛЭГЧИЙГ УНТРААХ

4.1 Телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон системд хүснэгт 3-д заасны дагуу шаттай шилжүүлнэ.

**Хүснэгт 3. Шилжилтийн хугацаа**

Үе шат	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Хамрах хүрээ
Тоон нэвтрүүлэгчийг асааж эхлэх	2014.07.31	2014 оны 4-р улирал	Бүх бүс нутагт
Аналоги нэвтрүүлэгчийг унтраах	2015 оны 1-р улирал	2017.07.31	Бүх бүс нутагт

- 4.2 “Монгол Улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх шилжилтийн үед баримтлах чиглэл<sup>1</sup>”-ийн 4.1.1-д заасныг үндэслэн Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар телевизийн газрын аналогийн сүлжээний нэвтрүүлэгчийг унтраах шийдвэрийг гаргана.

## 5. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

### 5.1. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл

- 5.1.1 Телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн аналогийн системд ашиглагдаж буй радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлүүдийн эцсийн хугацаа нь хүснэгт 3-д заасан аналог нэвтрүүлэгчийг унтраах хугацаагаар **буюу 2017 оны 07 сарын 31-ний** өдрөөр дуусгавар болно.
- 5.1.2 Энэхүү зохицуулалтын 5.1.1-д заасан хугацаанаас өмнө тухайн орон нутагт телевизийн аналогийн нэвтрүүлэгчийг унтраах шийдвэр гарсан тохиолдолд тухайн орон нутагт аналогийн системд ашиглагдаж буй радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болно.
- 5.1.3 Аналогийн нэвтрүүлэгчийг унтраах шийдвэр гарахаас өмнө аналогийн системд ашиглагдаж буй радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол шилжилтийн явц, энэхүү зохицуулалтын 5.1.1-д заасан хугацаатай уялдуулан Зохицуулах хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сунгах хугацааг шийдвэрлэнэ.
- 5.1.4 Радио давтамжийн тусгай зөвшөөрлийг телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч эзэмшинэ.
- 5.1.5 Телевизийн газрын сүлжээнд ашиглагдах радио давтамжийн тусгай зөвшөөрлийг олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч эзэмшиж болно.
- 5.1.6 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь телевизийн газрын сүлжээний радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшихгүй.
- 5.1.7 Телевизийн үйлчилгээ эрхлэгчид консорциум хэлбэрээр нэгдэж телевизийн газрын сүлжээний радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшиж болно.
- 5.1.8** Улаанбаатар хотод 5 хүртэл, аймгийн төвд 3 хүртэл, сум, суурин газруудад 2 хүртэл телевизийн газрын сүлжээний радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг өрсөлдүүлэн шалгаруулах зарчмаар олгоно.

---

<sup>1</sup> МТШХХГ-ын даргын 2012 оны 66 тоот тушаалаар батлагдсан.

## 5.2 Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл

- 5.2.1 Тоон технологид шилжсэний дараа болон тоон технологийн шилжилтийн үед радио, телевизийн үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан этгээдэд зөвхөн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгоно.
- 5.2.2 Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хугацааг “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын дагуу сунгуулна.
- 5.2.3 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгээ олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч болон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулна.
- 5.2.4 Телевизийн газрын сүлжээнд аналог системийн радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлтэй телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид холбогдох эрхтэй байна.
- 5.2.5 Телевизийн газрын сүлжээгээр радио өргөн нэвтрүүлэг дамжуулж болно.

### Телевизийн газрын сүлжээ

6.1 Телевизийн газрын сүлжээг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад нэг давтамжийн сүлжээ (SFN), бусад аймаг, сум, суурин газруудад олон давтамжийн сүлжээний (MFN) загвараар зохион байгуулна.

6.2 Зохицуулах хорооноос ОУЦХБ-ын стандарт, шаардлага хангасан программ хангамжаар нэвтрүүлэгчийн чадал, хамрах хүрээний урьдчилсан тооцооллыг хийж, телевизийн нэвтрүүлэгч болон антений байршлыг тогтооно.

А. Зохицуулах хороо нь телевизийн газрын сүлжээгээр дамжуулах өндөр нягтралтай (HD), стандарт нягтралтай (SD) телевизийн сувгийн тоог хүснэгт 2-т заасныг үндэслэн тогтооно.

Б. Телевизийн газрын сүлжээ эзэмшигч нь телевизийн студиэс телевизийн газрын сүлжээ хүртэлх сүлжээний суурилуулалт, ашиглалт үйлчилгээг хариуцна.

В. Телевизийн студиэс телевизийн газрын сүлжээ хүртэлх суурилуулалт, ашиглалт үйлчилгээний хөлсний хэмжээг (эсвэл тогтоосон үндэслэлийг) Зохицуулах хороогоор хянуулна.

төсөл

6.4 Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хоорондын харилцан холболтын зарчим болон төлбөрийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоож, хяналт тавина.

6.5 Тоон телевизийн газрын сүлжээнд тоон телевизийн төрийн сүлжээ, тоон телевизийн хувийн хэвшлийн сүлжээ хамаарна.

### **Тоон телевизийн төрийн сүлжээ**

7.1. Тоон телевизийн төрийн сүлжээ нь орон даяар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан телевизийн газрын сүлжээг хэлэх бөгөөд газрын сүлжээний ашиглалт үйлчилгээг төр (*Радио телевизийн сүлжээ УТҮГ*) хариуцна.

7.2. Тоон телевизийн төрийн сүлжээгээр төрөөс зайлшгүй дамжуулах телевизийн өргөн нэвтрүүлгийн сувгуудыг дамжуулна.

7.3. Тоон телевизийн төрийн сүлжээгээр орон даяар нэвтрүүлгээ дамжуулах радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийг Зохицуулах хороо 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан сонгон шалгаруулна.

7.4. Тоон телевизийн төрийн сүлжээгээр дамжуулах телевизийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон шалгаруулахдаа “Орон даяар нэвтрүүлгээ дамжуулах телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага”-ыг баримтлана.

7.5 Шилжилтийн хугацаанд тоон телевизийн төрийн сүлжээгээр телевизийн сувгуудыг зөвхөн стандарт нягтруулгатайгаар (SD) дамжуулна.

7.6 Шилжилтийн хугацаанд телевизийн аналог системийн радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн орон нутгийн тоон телевизийн төрийн сүлжээнд давуу эрхтэй холбогдоно.

### **Тоон телевизийн хувийн хэвшлийн газрын сүлжээ**

8.1 Тоон телевизийн хувийн хэвшлийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь зөвхөн телевизийн газрын сүлжээний ашиглалт үйлчилгээг дагнан эрхлэх бөгөөд радио телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмших эрхгүй байна.

8.2 Тоон телевизийн хувийн хэвшлийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь тухайн орон нутагт Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдийг сүлжээндээ холбох бөгөөд үйлчилгээ эрхлэгчдэд нээлттэй, ялгаварлахгүй хандана.

## 9 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

9.1 Телевизийн газрын сүлжээний тоног төхөөрөмж нь MNS 6400:2013 стандартыг, хүлээн авах төхөөрөмж нь MNS 6401:2013 стандартыг тус тус хангасан байна.

9.2 Телевизийн газрын сүлжээний тоног төхөөрөмж нь сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангасан байна.

9.3 Телевизийн нэвтрүүлэх болон хэрэглэгчийн хүлээн авах техник төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандарт шаардлагыг хангаж Зохицуулах хороогоор баталгаажилт хийлгэж, тохирлын гэрчилгээ авсан байна.

## 10 ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

10.1 Зохицуулах хороо, телевизийн үйлчилгээ эрхлэгчид хамтран телевизийн тоон систем, хүлээн авагчийн төрөл, түүний ашиглалтын заавар болон шилжилтийн хугацааны талаар олон нийтэд шилжилтийн хугацаа дуустал тогтмол мэдээлнэ.

10.2 Зохицуулах хороо шилжилтийн талаар тусгайлан вэб хуудас, зөвлөгөө лавлагаа өгөх тусгай дугаар ажиллуулах ба нэвтрүүлэг, мэдээлэл, сурталчилгаа бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

10.3 Телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн телевизээр МТШХХГ, Зохицуулах хорооны бэлтгэсэн болон өөрийн бэлтгэсэн шилжилтийн тухай нэвтрүүлэг, мэдээлэл сурталчилгааг идэвхитэй нэвтрүүлнэ.

10.4 Зохицуулах хороо шилжилтийн хугацаанд телевизийн үйлчилгээ эрхлэгчид болон телевизийн тоон хүлээн авагч нийлүүлэгчдэд зориулсан сургалт семинарыг зохион байгуулна.

10.5 Телевизийн тоон хүлээн авагч нийлүүлэгчид нь хүлээн авагчийн гарын авлагыг монгол хэлээр ойлгомжтой, хялбар байдлаар хэвлэн дагалдуулна.